



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/169.

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.2, Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Монгол Улсын бүсчилсэн хөгжил” дунд хугацааны хөтөлбөрийг шинээр боловсруулахад орон нутгийн саналыг тусгаж, мэдээ мэдээллээр ханган, санал хүргүүлэн ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Хуягбаатар (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд:

Б.Мөнгөн-Эрдэнэ	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга)
М.Алтаншагай	(Хууль, Эрх зүйн хэлтсийн дарга)
Б.Оюунтуяа	(Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
Ч.Ганбаатар	(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Г.Базар	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Б.Ганзориг	(Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын дарга)
М.Үүрийнбаяр	(Эрүүл мэндийн газрын дарга)
Б.Ганзориг	(Боловсрол шинжлэх ухааны газрын дарга)
П.Мөнхжаргал	(Байгаль орчин аялал жуучлалын газрын дарга)
Я.Эрхэмбаяр	(Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
С.Нарантуяа	(Соёлын хэлтсийн дарга)
Б.Батбаяр	(Мөрөн сумын Засаг дарга)

Нарийн бичгийн дарга:

Л.Занданмядагсүрэн (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

2. "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-ын төслөөр хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгээс гарсан саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, хамтран ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН